

**“СИЛИКАТ” ХК-ИЙН 2024 ОНД  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН.**

Дархан-уул аймаг.

2024 оны 04 сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд компанийн удирдлагаас хэрэгжүүлсэн авч хэрэгжүүлсэн ажлын тайланг та бүхэнд танилцуулъя. Үүнд:

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР.**

1. Тайлант хугацаанд буюу 2024 оны 05 сараас мөн оны 11 сар хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бага зэргийн saat ал, тасалдалтай боловч ихэнх тохиолдолд хэвийн явж ирсэн. Энэ хугацаанд компанийн ТУЗ болон үйлдвэрийн захиргаанаас гаргасан шийдвэрээр нэг ч ажилтан албан хаагчид, ажилчидыг орон тооны цомготголд оруулаагүй, үйлдвэрийн хэмжээнд ажлын байрыг хадгалах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Мөн үйлдвэрлэлийн жигд үйл ажиллагааг ханган ажиллахад онцгой анхаарч ажилласан.
2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдэрч шохойн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдрэх хүртэл 2024 онд хувьцаа эзэмшигчидэд тараах ногдол ашгийг тодорхой хугацаагаар хойшуулах саналаа ТУЗ-д танилцуулсанар хувьцаа эзэмшигчидэд ногдол ашгийг тараахгүй байх тухай шийдвэр гарсан.

Өнөөдрийн байдлаар 2024 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 70 хувьтай байна. Энэ нь дээрхи нөхцөл, шалтгаанаас шууд хамаарсан гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа ч төлөвлөсөн дараахи ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

**СИЛИКАТ ЦЕХ.**

1. Үйлдвэрлэлийн үр ашиг, ажлын цаг ашиглалт, ажлын цагийн бүтээмжийг дээшлүүлэх нэг үндсэн нөхцөл болох инженер, техникийн ажилтан, цехийн дарга ажилчидын ажил үүргийн хувиарт байсан зарим нэг давхардалыг арилгах үүднээс ажиллагсадын ажил үүргийн хуваарийг шинэчлэх замаар зохих өөрчлөлтийг хийлээ. Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сайн үр дүн авчирсан зүйл болсон гэж дүгнэж байна.

2. 2024 оны 04 сараас 11 сарыг дуусталх хугацаанд үйлдвэрлэлийн түүхий эдийг урьдчилан татаж бэлддэг байдлыг ажилд гарч байгаа бүх ээлжинд хэвшүүлснээр тухайн өдрийн ажлын цагийн үргэлжлэх хугацаанд стандарт, чанарын шаардлага бүрэн хангасан 40 тэргэнцэр хөнгөн бетон блок үйлдвэрлэх болсон.

Силикат цехийн зуурагчийн хурдыг 15-20 хувиар нэмэгдүүлж, зутангийн хөөсрөлтийг бүрэн хэмжээнд тогтмол өсгөдөг болсон.

Тэргэнцэрт зутан хийх, хэвлэгдсэн бүтээгдэхүүнийг автоклавт оруулахын өмнө хэв сугалах явцад гардаг байсан нурах эвдэрч гэмтэх зэрэг зөрчлүүдийг бүрэн арилгасан. Мөн цехийн тэргэнцэрийн зам ашиглалтыг нэмэгдүүллээ.

3. Автоклавын уур өгөлт, шаралтын хугацаа, горимын технологийг чанд мөрдсөнөөр 35-36.5 кг жинтэй, бэлэн бүтээгдэхүүний стандартын шаардлагыг бүрэн хангасан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон. Силикат цехийн тэргэнцэрийн нөөц замуудыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.

4. Силикат цехээс гарч байгаа бэлэн бүтээгдэхүүнийг гаднах талбайд цэгцэй хурааж, талбайн цэвэрлэгээг тогтмолжуулсан.

**5.** Силикат цехийн цахилгааны монтажийг шинэчлэн, схемжүүлэх болон газардуулагын ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрлөлтэй газраар гүйцэтгүүлсний дунд гарч болзошгүй цахилгааны гэмтэл, саатал болон цахилгааны монтаж, холболтоос үүдэн гарч болзошгүй аваар ослоос бүрэн хамгаалах нөхцөл бололцоог хангах үндсэн нөхцлийг бүдүүлсэн гэж дүгнэж байна. Үүний зэрэгцээ тус цехийн агааржуулалтын систем, хангамжид шинэчлэл, засвар үйлчилгээг хийснээр цехийн агааржуулалтыг эрс сайжирсан.  
Энэ бүхий үр дүнд ажиллагсадын ажлын байрны болон эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах үндсэн нөхцөл бололцоог тодорхой түвшинд дээшлүүлсэн.

## ШОХОЙН ЦЕХ БА УУЛЫН ХЭСЭГ.

**1.** Шохойн цехийн шатаах зууханд технологийн горимыг чанд мөрдүүлж хэвшилээр хоногт 70-80 хувийн идэвхжил бүхий, 90 хувийн шаталттай 25 тн шохой үйлдвэрлэх болсон.

**2.** Шохойн чулуу, нүурс тээвэрлэх конверүүдийн роликийг тогтмол хугацаанд шалган илэрсэн зөрчил, дутагдалыг тухай бүрд засаж, тэжээл дамжуулах дамжлагуудын хашлага, хаалтанд гарсан гэмтэлийг тухай бүр засварлахын зэрэгцээ ременүүдийн тохиргоонуудыг иж бүрнээр хийлээ.

Түүнчлэн дамжлагын конверүүдийн редуктор, хөдөлгүүрүүдийн тохиргоо, тохируулгыг бүрэн хийв.

**3.** Нүүрсний шигшүүрийг 0.5-1.5 мм болгон өөрчнөөр нүүрсний ашиглалтыг эрс сайжруулан, хаягдлын хэмжээг эрс бууруулсан сайхан мэдээг дуудгахад таатай байна. Энэ нь бүтээгдэхүүний өөрийн өртөг, зардал буурахад нөлөөлөх олон шалтгаануудын нэг болохыг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Чулууны нөөцийн бункерт шаардлагатай засвар, үйлчилгээг бүрэн хийсэн.

**4.** Уулын хэсгээс ирэх шохойн чулууны чанарт онцгойлон анхаарч шохойн чулуу бутлах, ялгах ангилах хэсэгт ажиллаж байгаа ажилчдын хөдөлмөрийн үнэлгээг шинэчлэн бодох арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ажиллагсадын сард авах цалингийн хэмжээ тодорхой хувиар нэмэгдэхийн зэрэгцээ гаргасан ажлын амжилт, бүтээл, сарын төлөвлөгөөний биелэлтийг харгалзан олгох шагнал урамшууллыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэж байна. Энэ бүгд нь тэдний ажлын чанарт тодорхой хэмжээнд нөлөөлөх болсныг дурьдахгүй өнгөрөхийн аргагүй юм.

Үүний зэрэгцээ чулуу хүлээн авах бункерийн зам, талбайг засварлан, чулуу бутлан, ангилах шигшүүрийг зохих түвшинд сайжруулан ажилласан болно.

**1.** Өөрийн болон гадны хөрөнгө оруулалтаар Шохойн үйлдвэрлэлийг өргөтгөх шинээр шохой шатаах зуух уулын хэсэгт байршуулах ажил нь 2023 онд нилээд гүйцэтгэл өндөртэй ажиллаж шинээр тоноглол төхөөрөмжүүд угсарсан.

Силикат цех болон Шохойн цехүүдэд дээрх ажилууд хийгдсэнээр үйлдвэрлэлийн жигд ажиллагаа бүтээгдэхүүний чанарт сайнаар нөлөөлсөн ч үйлдвэрлэлийн ашигтай ажиллагаанд хараахан нөлөөлж чадахгүй байна. Шинээр угсарч байгаа шохойн зуух бүрэн ашиглалтанд орсоноор дээрх хүндрэлээс гарна гэж үзэж байна. Ирэх жил санхүүгийн хүндрэлийн асуудлыг бүрэн шийдвэрлэхийн тулд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна. Ийм учраас дээрх анхаарах шаардлагатай санхүүжилт шохойн үйлдвэрийн өргөтгөлийн асуудлыг 2025 оны төлөвлөгөөндөө онцгой анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

ДАРХАН-УУЛ АИМАГ

“СИЛИКАТ”ХК-ИЙН ЗАХИРАЛ

СИЛИКАТ  
ХК

4515207260 № 2050463

Ц.СОДБИЛЭГ